

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотын “Эдийн засгийн форум-2019”-ийг 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсугай.

2.Эдийн засгийн форумыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

- |         |   |
|---------|---|
| Ахлагч: | -Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч   |
| Гишүүд: | -Нийслэлийн Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч,<br>-Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч ,<br>-Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч,<br>-Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч,<br>-Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга,<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга,<br>-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга,<br>-Нийслэлийн Засаг даргын зөвлөх,<br>-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Захиргаа, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/,<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, |

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга,
- Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга
- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга,
- Нийслэлийн Өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ХХК-ийн гүйцэтгэх захирал,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Захиргаа, бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/,
- Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/,
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх /зөвшилцсөнөөр/,
- Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд дэмжлэг үзүүлэх төслийн зохицуулагч /зөвшилцсөнөөр/,
- Шинжлэх Ухааны академийн мониторинг, дотоод хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга,
- Улаанбаатар Хөгжлийн корпораци ХХК-ийн гүйцэтгэх захирал.

Нарийн бичгийн дарга:

3. Эдийн засгийн Форумын бэлтгэл ажлыг сайтар хангаж, өндөр хэмжээнд зохион байгуулан, дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН